



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А1645

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсан сумдын Засаг дарга нарт олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулж, гэрээ байгуулан хүлээн авахыг хавсралтад заагдсан сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010888

Аймгийн Засаг даргын 2024 оны
 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/65 дугаар
 захирамжийн хавсралт



№	Төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг /төг/	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг /төг/	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын Засаг дарга
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	0.4 КВТ цахилгаан дамжуулах шугамын ажлын санхүүжилт (Баян-Агт сум)	40,000,000	40,000,000	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Баян-Агт сум Л.Эрдэнэбилэг
2	Гурванбулаг сумын ЗДТГ-ын барилгын засвар	120,000,000	120,000,000	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Гурванбулаг сум Б.Дэлгэр
3	Наадмын талбайн засвар (Сайхан сум)	60,000,000	60,000,000	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Сайхан сум Д.Сансар-Очир
Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт (Баян-Агт)	20,000,000	20,000,000	ШХА	Сар бүрийн 25-ны өдөр	Баян-Агт сум Л.Эрдэнэбилэг
	НИЙТ ДҮН	240,000,000	240,000,000			